

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЗАВХАН АЗЗА ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн
аудит

Аудитын код: САГ-2019/138/14-ТӨҮГ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардал, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар, тодруулга.....	7
2.11.	Шилэн дансны мэдээлэл	7
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	9
3.2	Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	10
3.3	Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	11
3.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
3.5	Аудит хийсэн зорилтот түвшин, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар, тодруулгын тайлан.....	13

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
АЗЗА	Авто замын засвар арчлалт
ТӨКХ	Төрийн өмчит хувьцаат компани



ЗАВХАН АЗЗА ТӨХК-ИЙН
ЗАХИРАЛ М.БОЛД ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.20 № 06/533
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Завхан АЗЗА ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Завхан АЗЗА ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Завхан АЗЗА ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Завхан АЗЗА ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Завхан АЗЗА ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал М.Болд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Завхан АЗЗА ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийлээ.

Завхан АЗЗА ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Завхан АЗЗА ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 20-ноос 03 дугаар сарын 05-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Завхан АЗЗА ТӨХК-ийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Эвиденсе Аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Завхан АЗЗА ТӨХК нь 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгын хамт 2019 оны 02 дугаар сарын 11-ны 16 тоот албан бичгээр Эвиденсе Аудит ХХК-д ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Завхан АЗЗА ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Завхан АЗЗА ТӨХК-ийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь Улсын чанартай автозам, замын байгууламжийн засвар, арчлалтын ажлыг чанартай гүйцэтгэж, замын хөдөлгөөний байнгын бэлэн байдлыг хангах явдал юм.

Завхан аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх 7 чиглэлийн 1,243.6 км автозам 928 гаруй у/м төмөр бетон болон модон гүүр болон 5 томоохон даваа болох Солонгот, Халзан Согоот, Ганц, Загастай, Агуйтын хөтөл зэрэгт жилийн дөрвөн улиралд тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллаж 1,103.7 сая төгрөг зарцуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэл:

- Хайрган болон хатуу хучилттай зам барих
- Хатуу болон хайрган хучилттай зам засварлах
- Төмөр бетон, ган төмөр, модон гүүр засварлах
- Үерийн хамгаалалтын далан барих
- Замын байгууламжинд хамаарах талбай барих, засах эрхийн дагуу үйл ажиллагаагаа өргөтгөн ажиллаж байна.

Завхан АЗЗА ТӨХК-ийн удирдлага дараах хууль болон түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- ААНОАТ-ын тухай хууль
- НӨАТ-ын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Авто замын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Завхан АЗЗА ТӨХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Завхан АЗЗА ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Завхан АЗЗА ТӨХК нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Макс” програм хангамж ашигладаг байна.

Завхан АЗЗА ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Завхан АЗЗА ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын үзүүлэлтийг сонгов.

Санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь уг компани нь төрийн өмчит компани, мөн бусад үзүүлэлтүүдээс хамгийн бага дүнтэй тул сонгосон ба материаллаг байдлын түвшинг тогтоохдоо хэрэглэгчдийн хэрэгцээ, өмнөх жилийн аудитын тайлангаар гарсан алдаа, зөрчлийн дүн, агуулгыг бас харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Завхан АЗЗА ТӨХК-ийн 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн Нийт орлого 1,088.6 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 10.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь тухайн байгууллага аудитын чиглэлүүдэд үзүүлж болзошгүй эрсдлийн “Дунд” үнэлгээг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа зөрчил илрээгүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардал, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар, тодруулга

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 673 дугаар тогтоолоор Завхан АЗЗА ТӨХК-ийн ТӨҮГ-ын 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилт түвшинг баталсан байна.

Тус компани нь 2018 оны зорилтот түвшинд нийт орлогыг 991.5 сая төгрөгөөр төлөвлөснөөс улсын чанартай зам засвар арчлалтын үйл ажиллагаанаас 574.6 сая төгрөг, орон нутгийн чанартай замын тендер болон бусад үйл ажиллагаанаас 416.9 сая төгрөг бүрдүүлэхээр тооцсон. Гүйцэтгэлээр улсын чанартай зам засвар арчлалтын үйл ажиллагаанаас 557.2 сая төгрөг, орон нутгийн чанартай замын тендер болон бусад үйл ажиллагаанаас 438.7 сая төгрөгний орлого олж орлогын төлөвлөгөөг 4.4 сая төгрөгөөр буюу 0.4 хувиар давуулан биелүүлсэн байна.

Нийт зардалд 976.5 сая төгрөг, үүнээс зам засвар арчлалтын зардалд 844.9 сая төгрөг, ерөнхий ба удирдлагын зардалд 131.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр зам засварын арчлалтын зардал 845.8 сая төгрөг, ерөнхий ба удирдлагын зардалд 135.1 сая төгрөг нийт зардалд 995.8 сая төгрөгийг зарцуулсан ба 11.9 сая төгрөгний цэвэр ашигтай ажилласан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Завхан АЗЗА ТӨХК-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн нэгтгэсэн мэдээллийг, зорилтот түвшний гүйцэтгэлийг, худалдан авалт, хагас жилийн санхүүгийн тайланг тус тус байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Завхан АЗЗА ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Завхан АЗЗА ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан**3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	212,902,733.67	85,179,090.52
1.1.2	Дансны авлага	264,076,967.24	297,547,305.77
1.1.3	Татвар НДШ-ийн авлага	84,500.00	84,500.00
1.1.4	Бусад авлага	-	442,349.81
1.1.6	Бараа материал	150,347,860.05	190,240,767.78
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	-	873,982.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	627,412,060.96	574,367,995.88
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	878,682,599.41	989,384,459.41
1.2.2	Биет бус хөрөнгө	-	101,756,606.05
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	878,682,599.41	1,091,141,065.46
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,506,094,660.37	1,665,509,061.34
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	147,404,866.42	53,827,847.79
2.1.1.2	Татварын өр	60,830,552.69	47,453,920.82
2.1.1.3	Богино хугацаат өр төлбөрийн дүн	208,235,419.11	101,281,768.61
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	291,360,199.00	291,360,199.00
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	291,360,199.00	291,360,199.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	499,595,618.11	392,641,967.61
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн	162,991,400.00	279,394,650.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	39,557,450.00	73,020,780.11
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	526,942,311.76	622,638,311.76
2.3.9	Хуримтлагдсан ашиг	277,007,880.50	297,813,351.86
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,006,499,042.26	1,272,867,093.73
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,506,094,660.37	1,665,509,061.34

3.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого(Цэвэр орлого)	964,170,555.34	1,075,832,822.15
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	808,796,561.02	926,210,205.69
3	Нийт ашиг (алдагдал)	155,373,994.32	149,622,616.46
5	Хүүний орлого	1,367,922.56	1,888,546.20
8	Бусад орлого	-	10,855,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	24,000,280.13
10	Ерөнхий ба удирдлагын зардал	130,730,519.77	105,116,598.72
12	Бусад зардал	6,799,693.00	10,252,439.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	19,211,704.11	22,996,844.81
19	Орлогын татварын зардал	2,601,139.71	2,299,684.48
20	Татварын дараах ашиг (алдагдал)	16,610,564.40	20,697,160.33
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	16,610,564.40	20,697,160.33
23	Бусад дэлгэрэнгүй орлого		95,696,000.00
23.3	Бусад олз/гарз		95,696,000.00
24	Орлогын нийт дүн		116,489,460.33

3.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	162,991,400.00	39,557,450.00	526,942,311.76	277,007,880.50	1,006,499,042.26
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
9	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	162,991,400.00	39,557,450.00	526,942,311.76	277,007,880.50	1,006,499,042.26
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-	-
11	Залруулсан үлдэгдэл	162,991,400.00	39,557,450.00	526,942,311.76	277,007,880.50	1,006,499,042.26
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				20,805,471.36	20,805,471.36
13	Өмчид гарсан өөрчлөлт	116,403,250.00		95,696,000.00		212,099,250.00
15	Зарласан ногдол ашиг				-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдэл		33,463,330.11		-	33,463,330.11
17	2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	279,394,650.00	73,020,780.11	622,638,311.76	297,813,351.86	1,272,867,093.73

3.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	948,778,246.50	1,165,823,400.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	947,423,246.50	1,164,823,400.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан	1,355,000.00	1,000,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	924,430,436.96	513,356,400.00
1.2.1	Ажилчдад төлсөн мөнгө	142,902,961.40	181,512,300.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	39,328,988.00	54,817,900.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	7,200,000.00	54,381,900.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	969,439.00	200,400.00
1.2.5	Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн	654,162,016.56	-
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	5,217,100.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	72,017,639.00	203,242,500.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	7,849,393.00	13,984,300.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	24,347,809.54	652,467,000.00
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,367,922.56	12,743,500.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	10,855,000.00
2.1.6	Бусад урт хугацаат хөрөнгө оруулалт	1,367,922.56	1,888,500.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	56,324,377.20
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		56,324,377.20
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны дүн	1,367,922.56	-43,580,877.20
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	736,609,765.95
3.2.1	Зээл өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		736,609,765.95
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	-	-736,609,765.95
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	25,715,732.10	-127,723,643.15
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	187,187,001.57	212,902,733.67
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	212,902,733.67	85,179,090.52

3.5 Аудит хийсэн зорилтот түвшин, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар, тодруулгын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /мянган төгрөгөөр/

Д/Д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2018		Зөрүү	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Дүн (Илүү+, Дутуу-)
1	Улсын чанартай авто зам засвар арчлалтын ажил	574,579.0	557,160.0	97.0	-17,419.0
	Орон нутгийн чанартай авто зам засвар арчлалтын ажил	416,900.0	438,672.0	105.2	21,772.0
	Нийт орлого	991,479.0	995,832.0	100.4	4,353.0
2	Нийт зардал	976,523.0	980,939.8	100.5	4,416.8
	Үүнээс: Удирдлагын захидал	131,573.4	135,137.4	102.7	3,564.0
3	Татварын өмнөх ашиг, алдагдал	14,956.0	14,892.2	99.6	-63.8
4	Цэвэр ашиг (алдагдал)	13,460.4	13,403.0	99.6	-57.4
5	Төсвийн төлбөрт нийт дүн	4,860.7	123,483.7		
6	Төрийн өмчийн ноогдол ашиг	2,692.1	1,661.0	61.7	-1,031.1
7	Нийт ажиллагсдын тоо	48	48	100.0	-
8	Нийт цалингийн сан	266,555.0	267,586.0	100.4	1,031.0
9	Нэг ажилтны дундаж цалин	462.8	464.6	100.4	1.8
10	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	1.0	1.0	101.0	0.0
11	Хөрөнгө оруулалт	15,000.0	15,000.0	100.0	-
12	Нийт авлага	165,945.00	84,005.9	50.6	-81,939.1
13	Нийт өглөг	436,984.2	361,247.3	82.7	-75,736.9
	Богино хугацаат өр	145,624.0	69,887.1	48.0	-75,736.9
	Урт хугацаат өр төлбөр	291,360.20	291,360.2	100.0	-

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for writing. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for writing. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.